

## ТАНИЛЦУУЛГА

2010 оны 7 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### Нэг. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

1. Цагдаагийн байгууллага 2010 оны эхний хагас жилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 45629 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсаны 22797 буюу 50.0 хувийг гэмт хэргийн гомдол, мэдээлэл эзэлж байна.


### Хоёр. Гэмт хэргийн байдал

1. Улсын хэмжээнд энэ оны эхний хагас жилд 9879 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 845 хэргээр буюу 7.9 хувиар буурчээ.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 55.7 хувь нь нийслэл хотод, 42.6 хувь нь аймгуудад, 0.9 хувь нь Төмөр замын салбарт, 0.8 хувь нь бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн гаралт Баян-Өлгий, Дархан-Уул, Архангай, Говь-Алтай, Орхон аймагт 1.7-49.7 хувиар, нийслэлийн Баянгол, Налайх дүүрэгт 2.8-26.6 хувь, Төмөр замын салбарт 23.2 хувь, бусад газарт 2.7 дахин өсөв.

Гэмт хэргийн гаралт өссөн аймаг /хувиар/




Гэмт хэргийн гаралт өссөн дүүрэг /хувиар/




Харин нийслэлд 6.8, Баянзүрх, Багануур, Хан-Уул, Сүхбаатар, Сонгинохайрхан Чингэлтэй, Багахангай дүүрэгт 1.8-57.1 хувиар, Дорноговь, Сэлэнгэ, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дорнод, Булган, Төв, Дундговь, Завхан аймагт 3.0-44.9, Иргэний агаарын тээврийн салбарт 81.8 хувиар тус тус буурч Увс аймаг өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо



Гэмт хэргийн гаралт буурсан аймаг /хувиар/




Гэмт хэргийн гаралт буурсан дүүрэг, салбар /хувиар/



Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 40.2 хувийг хөнгөн, 47.0 хувийг хүндэвтэр, 10.8 хувийг хүнд, 2.0 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж байгаа ба хөнгөн ангиллын гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 0.5, хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 13.2, хүнд ангиллын гэмт хэрэг 9.7 хувиар тус тус буурч онц хүнд ангиллын гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал




2010 оны эхний 6 сарын байдлаар 18 ба түүнээс дээш насны 10000 хүн тутамд улсын дунджаар 55 гэмт хэрэг ногдож байгаа нь

өмнөх оны мөн үеийнхээс 7 хэрэг буюу 11.3 хувиар буурсан байна.

Дээрх үзүүлэлт Дорноговь аймагт 77, Говьсүмбэр аймагт 74, Хэнтий аймагт 66, Сэлэнгэ аймагт 57 байгаа нь улсын дунджаас 3.6-40.0 хувиар, нийслэлд 74 байгаа нь 34.5 хувиар илүү, Дорнод аймагт 54.1, Дархан-Уул аймагт 50.2, Өмнөговь аймагт 48.7, Төв аймагт 48.0, Увс аймагт 45.4, Орхон аймагт 45.0, Архангай аймагт 40.1, Баянхонгор аймагт 39.1, Дундговь аймагт 35.0, Баян-Өлгий Ховд аймагт тус бүр 33.8, Булган аймагт 30.0, Хөвсгөл аймагт 27.4, Говь-Алтай аймагт 26.9, Өвөрхангай аймагт 25.1, Сүхбаатар аймагт 23.2, Завхан аймагт 17.9 байгаа нь улсын дунджаас 1.8-69.1 хувиар бага байна.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 39.1 хувьтай, өмнөх оны мөн үеийнхээс 1.2 пунктээр буурч, нийслэлийн хэмжээнд 39.4 хувьтай, өмнөх оны мөн үеийнхээс 1.8 пунктээр өссөн статистик үзүүлэлттэй байна.


Гэмт хэргийн илрүүлэлт /хувиар/



Гэмт хэргийн илрүүлэлт Дорноговьд 57.6, Сүхбаатарт 57.6, Дундговьд 56.8, Говь-Алтайд 55.8, Дархан-Уулд 54.9, Баянхонгорт 54.7, Өвөрхангайд 50.0, Увсад 47.2, Хэнтийд 44.5, Ховдод 44.1, Архангайд 40.9, Булганд 40.0, Говьсүмбэрт 36.0, Баян-Өлгийд 35.9, Сэлэнгэд 33.0, Орхонд 32.3, Завханд 27.8, Төвд 22.2, Өмнөговьд 19.2, Дорнодод 14.8, Хөвсгөлд 4.9, нийслэлийн Налайхад 54.8, Баянголд 51.7, Сүхбаатарт 46.4, Баянзүрхэд 44.5, Чингэлтэйд 34.6, Хан-Уулд 32.4, Багануурт 31.1, Сонгинохайрханд 26.5, Төмөр замын салбарт 47.6 хувьтай байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийг ангиллаар нь тооцож үзвэл: Хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 36.0, хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 37.9, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 55.1, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 48.4 хувьтай байгаа нь хөнгөн хэргийн илрүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс 1,0, хүнд хэргийн илрүүлэлт 3.1 пунктээр өсч, хүндэвтэр хэргийн илрүүлэлт 1.0, онц хүнд хэргийн илрүүлэлт 26.3 пунктээр буурчээ.


Гэмт хэргийн илрүүлэлт /ангилал, хувиар/



Мал хулгайлах гэмт хэрэг 435 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 36.8 хувиар буурч, нийт хэргийн 4.4 хувийг, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэргийн 15.3 хувийг, тээврийн хэрэгсэл хулгайлах гэмт хэрэг 47 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийн түвшинд байгаа ба хулгайлах хэргийн 1.7 хувийг, халаасны хулгайн хэрэг 85 бүртгэгдэж, хулгайлах хэргийн 3.0 хувийг тус тус эзэлж байна.

2010 оны эхний хагас жилд 194353 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 184124 иргэн, 14 албан тушаалтан, 272 аж ахуйн нэгж, байгууллагад шийтгэл тус тус ногдуулсан байна.


Аймгуудад бүртгэгдсэн захиргааны зөрчлийн тоо



2010.I-VI

Бүртгэгдсэн бүх зөрчлийн 62418 буюу 32.1 хувь нь аймгуудад, 34338 буюу 17.7 хувь нь нийслэлийн дүүргүүдэд, 91507 буюу 47.1 хувь нь Замын цагдаагийн газарт, 3416 буюу 1.8 хувь нь Төмөр замын салбарт, 2099 буюу 1.1 хувь нь Хөдөлгөөнт эргүүлийн газарт, 575 буюу 0.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.


**Дүүрэг, бусад нэгжид бүртгэгдсэн  
захиргааны зөрчлийн тоо**



2010.I-VI

2010 оны эхний 6 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 41916 хүн эрүүлжүүлсэний 24504 буюу 58.5 хувь нь нийслэлд, 17412 буюу 41.5 хувь нь аймгуудад эрүүлжүүлэгдсэн байна.

**Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн  
нийгмийн байдал**



2010.I-VI